

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/01/-НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Алтай хот            2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа</p> <p>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг</p> <p>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Цэрэнханд, М.Атарцэцэг</p> <p>Аудитор: Н.Гэрэлмаа</p> <p>Утас: 99086371, 88984411, 99782918</p> <p>Цахим хаяг:govialtai@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03.17 № 113

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 632 дугаар тогтоолоор үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тарифт өөрчлөлт орсон байна.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн ТУЗ-ын тогтоолоор Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг шинэчилсэн баталжээ.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн ТУЗ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор Компанийн ажилтнуудын үндсэн цалинг 15.0 хувиар нэмэгдүүлсэн.

### Аудитын гол асуудал

Анх баталсан төлөвлөгөөнөөс борлуулалтын орлогыг 885,590.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлогыг 500,000.0 мянган төгрөгөөр, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийг 3,925,400.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,969,380.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна. Улсын төсвөөс авах татаас санхүүжилт нэмэгдсэн нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,596,536.1 мянган төгрөг, урт хугацаат зээлийн төлбөр 668,600.0 мянган төгрөгийг төлөхтэй холбоотойгоор Эрчим хүчний яамнаас санхүүжүүлсэн байна.

8225020321

Мөн Эрчим хүчний сайдын 2024 оны А/225 дугаар тушаалаар баталсан их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 3,251,300.0 мянган төгрөгийн 61 ажлаас 1,951,118.5 мянган төгрөгийн 55 ажлыг хэрэгжүүлсэн байна.

Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан зэргээс шалтгаалан өмнөх онуудын татварын өр төлбөрийн алданги, торгуульд тайлант онд 99,443.1 мянган төгрөгийг төлсөн нь аж ахуй нэгжийн үр дүнгийн үзүүлэлтийг бууруулсан байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 9 зорилтын хүрээнд 124 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бөгөөд гүйцэтгэлийн тайлангийн биелэлтийг 95.3 хувиар тооцож гаргасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцээгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>3</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,420,309,273.8</u></b>	<b><u>7,028,346,716.9</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,824,316,433.2	3,876,945,922.4
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	1,824,316,433.2	3,876,945,922.4
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1,824,316,433.2	3,876,945,922.4
31213	Арилжааны банк дахь харилцах	1,824,316,433.2	3,876,945,922.4
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	657,544,085.9	680,149,513.6
33401	Дансны авлага /ТӨҮГ/	648,447,506.2	651,241,943.8
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	5,493,787.7	25,304,777.9
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,602,792.0	3,602,792.0
3351	Байгууллагаас авах авлага	3,602,792.0	3,602,792.0
	<b>Урьдчилж төлсөн зардал/тооцоо</b>	538,545,103.7	406,172,851.0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,399,903,651.0	2,065,078,429.9
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,399,903,651.0	2,065,078,429.9
35410	Бичиг хэргийн материал	40,642,012.5	33,518,530.5
35420	Аж ахуйн материал	149,554,164.6	102,397,483.1
35430	Сэлбэг хэрэгсэл	1,614,535,276.2	1,243,369,318.8
35440	Түлш, шатах тослох материал	165,190,428.1	266,340,189.9
35470	Бусад хангамжийн материал	429,981,769.7	419,452,907.7
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>93,532,008,390.9</u></b>	<b><u>93,585,864,052.6</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	93,532,008,390.9	93,585,864,052.6
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	88,457,736,039.9	88,451,514,360.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	68,294,403,711.8	70,278,577,647.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,913,835,202.6)	(15,704,104,786.4)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,630,886,369.2	1,776,564,805.5
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,246,106,187.6)	(1,248,140,173.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,331,268,745.8	57,951,921,152.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,014,701,220.8)	(25,008,209,156.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	390,349,037.0	406,243,223.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	(299,444,251.4)	(318,082,483.2)
39214	Бусад үндсэн хөрөнгө	610,288,413.5	679,954,188.4
39215	Хуримтлагдсан элэгдэл	(325,373,375.0)	(363,210,057.5)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,074,272,351.0	5,134,349,692.5
39303	Бусад биет бус хөрөнгө	5,207,839,045.0	5,307,759,045.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	(133,566,694.0)	(173,409,352.5)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>98,952,317,664.7</u></b>	<b><u>100,614,210,769.5</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>43,654,837,963.8</u></b>	<b><u>43,397,531,342.9</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	180,650,914.8	592,031,076.5
<b>413</b>	<b>Өглөг</b>	180,650,914.8	592,031,076.5
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	141,637,851.5	539,546,294.0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	44,349,721.0	503,183,936.4
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	52,250.0	67,925.0
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	73,449,713.2	36,294,432.5
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	39,013,063.4	52,484,782.5
41440	Бусад урьдчилж орсон орлого	39,013,063.4	52,484,782.5
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	43,474,187,049.0	42,805,500,266.4
<b>422</b>	<b>Урт хугацаат зээл</b>	43,474,187,049.0	42,805,500,266.4
<b>4221</b>	<b>Төгрөг</b>	43,474,187,049.0	42,805,500,266.4
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	43,474,187,049.0	42,805,500,266.4
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>55,297,479,700.9</u></b>	<b><u>57,216,679,426.6</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	88,688,608,471.8	90,529,706,650.0

**Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	88,688,608,471.8	90,529,706,650.0
51102	- төрийн	60,388,037,164.6	60,388,037,164.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	28,300,571,307.2	30,141,669,485.4
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(33,391,128,770.9)</b>	<b>(33,313,027,223.4)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(39,157,888,337.6)	(39,208,997,629.3)
51220	Тайлант үеийн үр дүн	-	129,210,839.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,766,759,566.7	5,766,759,566.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>98,952,317,664.7</b>	<b>100,614,210,769.5</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

**(төгрөгөөр)**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	19,062,724,650.5	22,848,577,820.9
02	Борлуулалтын өртөг	19,281,388,991.7	21,404,843,526.9
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(218,664,341.2)</b>	<b>1,443,734,294.0</b>
04	Түрээсийн орлого	0.0	6,760,000.0
05	Хүүний орлого	12,545,155.3	40,573,352.6
08	Бусад орлого	1,379,570,417.5	5,719,926,580.1
08.1	Орлогын дүн	1,392,115,572.9	5,767,259,932.7
09	Борлуулалт, маркетингийн зардал	1,370,237,934.4	1,870,344,619.1
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,693,854,233.3	4,442,181,994.8
12	Бусад зардал	231,675,032.1	323,448,415.6
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>5,295,767,199.7</b>	<b>6,635,975,029.5</b>
17	Бусад ашиг ( алдагдал)	(4,750,000.0)	(57,674,535.9)
<b>17.1</b>	<b>Олз, гарзын дүн</b>	<b>(4,750,000.0)</b>	<b>(57,674,535.9)</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(4,127,065,968.0)</b>	<b>517,344,661.3</b>
19	Орлогын татварын зардал	31,403,874.5	388,133,822.0
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(4,158,469,842.5)</b>	<b>129,210,839.2</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(4,158,469,842.5)</b>	<b>129,210,839.2</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**(төгрөгөөр)**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>20,014,617,849.0</b>	<b>50,238,580,201.2</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,066,776,193.6	25,755,729,827.6
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,864,235.9	6,944,121.0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,394,975,809.1	6,125,400,000.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	542,001,610.4	18,350,506,252.6
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>18,977,268,163.1</b>	<b>46,612,577,517.2</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,011,924,013.1	9,888,722,139.1
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,238,325,901.1	2,181,944,239.8
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,352,317,938.5	6,301,939,441.3
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	62,990,352.8	104,123,753.4

**Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,007,071,922.5	819,325,335.5
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	0.0	76,306,233.5
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,164,819,631.4	4,080,368,676.3
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	28,385,552.0	19,075,834.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,111,432,851.7	23,140,771,864.3
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,037,349,685.9	3,626,002,684.0
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	79,317,479.8	30,163,849.7
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	57,495,320.0	2,600,000.0
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	3,159.8	27,563,849.7
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,000,000.0	1,603,537,044.6
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,000,000.0	1,603,537,044.6
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	62,317,479.8	(1,573,373,194.8)
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,099,667,165.7</b>	<b>2,052,629,489.2</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>25,914,304.9</b>	<b>1,824,316,433.2</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,824,316,433.2</b>	<b>3,876,945,922.4</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

**(төгрөгөөр)**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

№	Үзүүлэлт	Хувийн өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	60,388,037,164.6	28,298,529,640.6	5,766,759,566.7	(34,999,418,498.1)	59,453,907,873.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	3.0	3.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,388,037,164.6	28,298,529,640.6	5,766,759,566.7	(34,999,418,495.1)	59,453,907,876.8
4	Өмчид гарсан өөрчлөлт	-	2,041,666.6	-	-	2,041,666.6
6	Тайлант үеийн үр дүн	-	-	-	(4,158,469,842.5)	(4,158,469,842.5)
7	2022 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	60,388,037,164.6	28,300,571,307.2	5,766,759,566.7	(39,157,888,337.6)	55,297,479,700.9
8	2023 оны 1-р сарын 1-нэрэх үлдэгдэл	60,388,037,164.6	28,300,571,307.2	5,766,759,566.7	(39,157,888,337.6)	55,297,479,700.9
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	(51,109,291.7)	(51,109,291.7)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,388,037,164.6	28,300,571,307.2	5,766,759,566.7	(39,208,997,629.3)	55,246,370,409.2
11	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,841,098,178.2	-	-	1,841,098,178.2
13	Тайлант үеийн үр дүн	-	-	-	129,210,839.2	<b>129,210,839.2</b>
14	2024 оны 12-р сарын 31-нарх үлдэгдэл	60,388,037,164.6	30,141,669,485.4	5,766,759,566.7	(39,079,786,790.1)	57,216,679,426.6

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

ГАА-2025/001/НА-СТА-ТӨҮГ

**Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан**

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	2024 оны төлөвлөгөөтэй харьцуулалт		
					Хэмнэлт, хэтрэлт	Хувь	
		1	3.0	4.0	5.00		
1	Нийт дамжуулах	сая кВт.ц	132.0	134.9	2.97	102.2%	
	Худалдаж авсан ЦЭХ	сая кВт.ц	70.2	71.1	0.90	101.3%	
	ТБНС	сая кВт.ц	66.4	67.6	1.22	101.8%	
	ББЭХС	сая кВт.ц	3.5	3.4	- 0.10	97.2%	
	БНХАУ	сая кВт.ц	0.3	0.1	- 0.23	19.5%	
	Үйлдвэрлэсэн ЦЭХ	сая кВт.ц	61.8	63.9	2.07	103.4%	
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	2.2	2.1	- 0.03	98.4%	
		хувь	3.5	3.3	- 0.17	95.2%	
	Цахилгаан эрчим хүч түгээлт	сая кВт.ц	129.8	132.8	3.00	102.3%	
	ЦЭХ-ний алдагдал	сая кВт.ц	24.9	25.4	0.45	101.8%	
		хувь	0.2	0.2	- 0.00	99.5%	
Борлуулах цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	104.9	107.5	2.55	102.4%		
2	<b>Нийт орлого</b>	<b>сая төг</b>	<b>24,649.3</b>	<b>25,908.0</b>	<b>1,258.8</b>	<b>105.1%</b>	
	Үйл ажиллагааны орлого	сая төг	18,552.2	20,137.5	1,585.3	108.5%	
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	171.7	202.0	30.3	117.7%	
	Улсын төсвийн татаас	сая төг	5,925.4	5,568.5	- 356.8	94.0%	
3	<b>Нийт зардал</b>	<b>сая төг</b>	<b>26,822.8</b>	<b>25,778.8</b>	<b>- 1,044.0</b>	<b>96.1%</b>	
	Цалин шимтгэл	сая төг	11,844.5	11,086.5	- 758.0	93.6%	
	Үйл ажиллагааны зардал	сая төг	6,505.2	5,915.7	- 589.5	90.9%	
	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая төг	4,462.9	4,325.5	- 137.4	96.9%	
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	-	492.6	492.56		
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	сая төг	4,010.2	3,958.6	- 51.62	98.7%	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая төг	-	2,173.5	621.8	2,795.3	-28.6%
5	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>сая төг</b>	<b>- 2,173.5</b>	<b>129.2</b>	<b>2,302.8</b>		
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төг	1.1	1.0	- 0.1	91.4%	
7	<b>Нийт авлага</b>	<b>сая төг</b>	<b>700.0</b>	<b>680.1</b>	<b>- 19.9</b>	<b>97.2%</b>	
	ЦЭХ-ний	сая төг	700.0	680.1	- 19.85	97.2%	
	Бусад	сая төг	-	-	-		
8	<b>Нийт өглөг</b>	<b>сая төг</b>	<b>43,474.2</b>	<b>43,397.5</b>	<b>- 76.7</b>	<b>99.8%</b>	
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	43,474.2	42,805.5	- 668.69	98.5%	
	Богино хугацаат өр төлбөр	сая төг		592.0	592.03		
9	Нийт ажиллагсад	тоо	368.0	368.0	-	100.0%	
10	<b>Нийт цалингийн сан</b>	<b>сая төг</b>	<b>10,723.9</b>	<b>10,080.6</b>	<b>- 643.35</b>	<b>94.0%</b>	
11	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>сая төг</b>	<b>3,251.9</b>	<b>1,951.1</b>	<b>- 1,300.73</b>	<b>60.0%</b>	

### 3. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар илэрсэн 1,393,883.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг 13,456,8 мянган төгрөгөөр,
- Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 371,554.7 мянган төгрөгөөр, зардлыг 1,004,893.8 мянган төгрөгөөр,
- Үндсэн хөрөнгийн тайланд хөрөнгийг 3,978.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, нийт 1,393,883.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 296,896.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 296,896.3 мянган төгрөгийн 26 зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 18,948.2 мянган төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 260,450.0 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 23 албан шаардлага, 17,498.1 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Төлбөрийн акт

1. Тосонцэнгэл УЦС ХХК нь ажиллагсад олгосон 5,052.0 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмжээс 505.2 мянган төгрөгийн татварыг суутган шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дараах орлогыг албан татвараас чөлөөлнө. 22.1.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү суутгасан 505.2 мянган төгрөгийг ажилчдад нөхөн олгох төлбөрийн акт тогтоосон.

2. Завхан салбар нь ээлжийн амралтаа эдэлж ажилдаа орсон ажилтны цагийн бүртгэлийг буруу гаргаснаас 259.6 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон цалинг ажилтанд нөхөн олгох төлбөрийн акт тогтоосон.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Богдын голын УЦС ХХК нь германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтын томилолтын зардлыг давхардуулан 2,095.0 мянган төгрөгийг 2 ажилтанд олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" нь гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон томилолтын зардлыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

4. Богдын голын УЦС ХХК нь ажилтны амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 509.4 мянган төгрөг, Тайшир Гуулин УЦС ХХК нь 742.2 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон мөнгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5. Тайшир Гуулин УЦС-ын гүйцэтгэх захирал өөртөө тушаал гарган 950.4 мянган төгрөгийн шагнал, урамшуулал авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр олгосон шагнал, урамшууллыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

6. Тайшир Гуулин УЦС-ын гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүйгээр ажилтанд 3,293.3 мянган төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр олгосон нөхөн олговрыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, байгууллагын зорилтот түвшинд батлаагүй байхад байгууллагын төсвөөс 6,186.6 мянган төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж зорилтот түвшин зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байхад олгосон шагнал, урамшууллыг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

8. Хөрөнгө оруулалтын 15 төсөл арга хэмжээг гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүйд 4,262.5 мянган төгрөгийн алдангийг тооцож төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Гүйцэтгэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ"-д заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүйд ногдох алдангийг гүйцэтгэгч байгууллагаар төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

9. Хувь хүнээс суутган төлөх 144.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг байгууллагаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс төлсөн нь актын төлбөрийг төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### 3.3 Албан шаардлага

1. АУЭХС ТӨХК, Завхан салбар, Тосонцэнгэл УЦС ХХК нь санхүүгийн тайланд тусгасан 36,240.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд тусгасан өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулан үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тосонцэнгэл УЦС ХХК нь батлагдсан эдийн засгийн зорилтот түвшин, төлөвлөгөөнд тусгаагүй гагнуурчин, сахиулын ажлыг хавсруулан 3,961.3 мянган төгрөгийн цалин олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах"; Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2024 оны 10 сарын 21-ны өдрийн А/225 дугаар тушаал "Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг шинэчлэн батлах тухай"-тай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны дагуу ажиллаж, ажил хавсран олгосон урамшуулал олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайшир Гуулин УЦС, Богдын голын УЦС ХХК-ууд нь үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан зэргээс шалтгаалан өмнөх онуудын татварын өр төлбөрийн алданги, торгуульд тайлант онд 99,443.1 мянган төгрөгийг төлж нь аж ахуй нэгжийн ажлын хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг бууруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Захирал нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2024 оны 10 сарын 21-ний өдрийн А/225 дугаар тушаал "Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин шинэчлэн батлах тухай", Алтайн-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий 2024/01 дугаартай хөдөлмөрийн гэрээний 1.4-т Эрчим хүчний яамнаас баталсан "Алтайн-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гүйцэтгэх захирлын гүйцэтгэх ажлын үр дүн болно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг үр ашиг, үр дүнтэй захиран зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тосонцэнгэл УЦС ХХК нь төсвийн төсөл, батлагдсан эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 3,200.0 мянган төгрөгийг шагнал урамшуулал, 2,355.3 мянган төгрөгийн дизель түлшний зардалд тус тус зарцуулж, тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2024 оны 10 сарын 21-ний өдрийн А/225 дугаар тушаал "Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг шинэчлэн батлах тухай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан эдийн засгийн зорилтот түвшинд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Систем компанийн хэмжээнд нэгээс дээш жил ашиглагдах 113,029.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалыг шаардах хуудсаар шууд зарлагадаж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 7.3 Бараа материалын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд заасан заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

6. Завхан салбар нь тушаалаар олгох 6,450.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн нэмэгдэл хэлбэрээр тооцож, 1,602.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдад олгосон шагналаас нийгмийн даатгал суутган төлсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

7. Завхан салбар, Тайшир Гуулин УЦС, Богдын голын УЦС ХХК-иуд нь Төлөөлөн удирдахын тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгаагүй, 13,819.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2024 оны 10 сарын 21-ний өдрийн А/225 дугаар тушаал "Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг шинэчлэн батлах тухай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх шаардлага хүргүүлсэн.

8. Завхан салбар нь Улиастай 0.4 квт цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх ажлыг 2015 онд дутуу хүлээлгэн өгснөөс үүссэн урьдчилж төлсөн зардал 50,933.2 мянган төгрөг данс бүртгэлд бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

9. Тайшир Гуулин УЦС ХХК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд орлогыг 1,325.2 мянган төгрөгийг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр

дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах"; гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын тайланг үнэн зөв тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

10. АУЭХС ТӨХК нь жолоочийн тооцооны хуудсанд хаашаа ямар ажлаар явсан нь тодорхой бусаар 2,486.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, бүрэн хөтөлж байх албан шаардлага хүргүүлсэн.

11. АУЭХС ТӨХК нь тайланд 2022 онд үүссэн 7,496.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын урьдчилж төлсөн тооцоог 2024 онд хаасан боловч тооцоо нийлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагатай тооцоо нийлсний дараа өглөг, авлагыг хаах бичилт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

12. АУЭХС ТӨХК-ний жолоочийн тооцооны хуудсыг тулган баталгаажуулахад 10 автомашины спидометрийн заалт зөрүүтэй хөтөлсөн зөрчлийг арилгаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Илрүүлэлт:1

Тосонцэнгэл УЦС ХХК нь татвар ногдох үл хөдлөх хөрөнгийг татварын цахим системд бүрэн бүртгээгүйгээс шалтгаалан 949.5 мянган төгрөгийн татварыг дутуу ногдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон

улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Монгол Улсын Иргэний хуулийн 84.3-т заасны дагуу тодорхойлогдсон бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгөд албан татвар ногдуулна". 5 дугаар зүйлийн 5.1-т "Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хэлтэст татвар ногдох үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг үнэн зөв тайлагнах.

#### Илрүүлэлт:2

Завхан салбар, Тайшир Гуулин УЦС ХХК нь 10,912.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, эрчим хүчний тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг сольж засварласан талаар техникийн комисс ажилласан нь тодорхогүй, акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаалын хавсралт "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм"-ийн 1 дүгээр зүйлийн 1.6.4-т "Эрчим хүчний үйлдвэр байгууллагуудад тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ашиглалтын явцад гарсан болон үзлэг шалгалтаар илэрсэн эвдрэл гэмтэл, аваари саатал, тасралт татгалзал зэрэг бүх төрлийн зөрчил доголдуудад нэг бүрчилсэн нарийн бүртгэл тэмдэглэл, акт хөтлөгдөж байвал зохих бөгөөд," гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сэлбэг хэрэгслийг солихдоо техникийн комиссын дүгнэлтийг үндэслэж байх.

#### Илрүүлэлт:3

АУЭХС ТӨХК нь бараа материалын тайланд 5,636.4 мянган төгрөгийн дизель засварыг орлого авсан бөгөөд капиталжуулж бүртгээгүй нь Батлагдсан эдийн засгийн зорилтот түвшний биелэлтээр нийт орлого, зардал, алдагдлыг зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох стандарт, хууль, журмын дагуу хөрөнгийг бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:						Зөвлөмж			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Тоо		Дүн	
		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14				
1	2																
Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компани	Орлого, үр дүнгийн тайлангийн орлогын ангилал зөрүүтэй	5	13,456.8	-	-	5	13,456.8	5	13,456.8								
	Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлуудын ангилал зөрүүтэй	3	1,004,893.8	-	-	3	1,004,893.8	3	1,004,893.8								
	Мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын ангилал зөрүүтэй	1	371,554.7	-	-	1	371,554.7	1	371,554.7								
	Үндсэн хөрөнгийн тайланд хөрөнгө орлого аваагүй	4	3,978.0	-	-	4	3,978.0	4	3,978.0								
<b>Дүн</b>		<b>13</b>	<b>1,393,883.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>13</b>	<b>1,393,883.3</b>	<b>13</b>	<b>1,393,883.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>13</b>	<b>1,393,883.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компани	Ажиллагсад олгосон 5,052.0 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмжээс татвар суутган шилжүүлсэн.	1	505.2	1	505.2	-	-	-	-	-	-
	Батлагдсан эдийн засгийн зорилтот түвшин, төлөвлөгөөнд тусгаагүй гагнуурчин, сахиулын ажлыг хавсруулан 3,961.3 мянган төгрөгийн цалин олгосон.	1	3,961.3	-	-	1	3,961.3	-	-	-	-
	Санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	3	36,240.9	-	-	3	36,240.9	-	-	-	-
	Татвар ногдох үл хөдлөх хөрөнгийг татварын цахим системд бүрэн бүртгээгүйгээс шалтгаалан 949.5 мянган төгрөгийн татварыг дутуу ногдуулсан байна.	1	949.5	-	-	-	-	-	1	949.5	-
	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан зэргээс шалтгаалан өмнөх онуудын татварын өр төлбөрийн алдани, торгуульд тайлант онд 99,443.1 мянган төгрөгийг төлсөн нь аж ахуй нэгжийн ажлын хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг бууруулсан байна.	2	-	-	-	-	2	-	-	-	-
	Төсвийн төсөл, батлагдсан эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 3,200.0 мянган төгрөгийг шагнал урамшуулал, 2,355.3 мянган төгрөгийн дизель түлшний зардалд тус тус зарцуулж, тайлагнасан байна.	1	5,555.3	-	-	1	5,555.3	-	-	-	-
	Нэгээс дээш жил ашиглагдах сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалыг шаардах хуудсаар шууд зарлагдаж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	5	113,029.0	-	-	5	113,029.0	-	-	-	-
	Тушаалаар олгох 6,450.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн нэмэгдэл хэлбэрээр тооцож, 1,602.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн байна.	1	1,602.8	-	-	1	1,602.8	-	-	-	-

Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан	Ажилтанд 259.6 мянган төгрөгийн цалинг дууу тооцож олгосон байна.	1	259.6	1	259.6	-	-	-	-
	ТУЗ-ын тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.	3	13,819.9	-	-	3	13,819.9	-	-
	Улиастай 0.4 квт цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх ажлыг 2015 онд дууу хүлээлгэн өгснөөс үүссэн урьдчилж төлсөн зардал 50,933.2 мянган төгрөг данс бүртгэлд бүртгэлтэй байна.	1	50,933.2	-	-	1	50,933.2	-	-
	Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтын томилолтын зардлыг давхардуулан 2,905.0 мянган төгрөгийн томилолтын мөнгө олгосон.	1	2,095.0	1	2,095.0	-	-	-	-
	Ажилтны амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан олгосон.	2	1,251.6	2	1,251.6	-	-	-	-
	Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүйгээр ажилтанд 3,293.3 мянган төгрөгийг амралтын нөхөн олговрыг тооцож олгосон.	1	3,293.3	1	3,293.3	-	-	-	-
	Гүйцэтгэх захирал өөртөө тушаал гарган 950.4 мянган төгрөгийн шагнал авсан.	1	950.4	1	950.4	-	-	-	-
	Байгууллагын зорилтот түвшинд батлаагүй байхад байгууллагын төсвөөс 6,186.6 мянган төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулсан байна.	1	6,186.3	1	6,186.6	-	-	-	-
	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд орлогыг 1,325.2 мянган төгрөгийг илүү тайлагнасан байна.	1	1,325.2	-	-	1	1,325.2	-	-
	Хувь хүнээс суутган төлөх 144.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг байгууллагаас төлсөн.	1	144.0	1	144.0	-	-	-	-
	Хөрөнгө оруулалтын 15 төсөл арга хэмжээг гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүйд 4,262.5 мянган төгрөгийн алдангийг тооцож төлүүлээгүй байна.	1	4,262.5	1	4,262.5	-	-	-	-
	Жолоочийн тооцооны хуудсанд хаашаа ямар ажлаар явсан нь тодорхой бусаар 2,486.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.	1	2,486.0	-	-	1	2,486.0	-	-

Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Бараа материалын тайланд 5,636.4 мянган төгрөгийн дизель засварыг орлого авсан бөгөөд капиталжуулж бүртгээгүй.	1	5,636.4	-	-	-	1	5,636.4	-	-
Тайланд 2022 онд үүссэн 7,496.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын урьдчилж төлсөн тооцоог 2024 онд хаасан боловч тооцоо нийлээгүй байна.	1	7,496.5	-	1	7,496.5	-	-	-	-
Жолоочийн тооцооны хуудсыг тулган баталгаажуулахад 10 автомашины спидометрийн заалт зөрүүтэй хөтөлсөн зөрчлийг арилгаагүй байна.	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>33</b>	<b>261,984.2</b>	<b>10</b>	<b>18,948.2</b>	<b>21</b>	<b>236,450.0</b>	<b>2</b>	<b>6,585.9</b>	<b>-</b>

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
												3
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компани	Тосонцэнгэл УЦС-ын 250,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй конторын барилга 2019 оноос баригдаж эхэлсэн бөгөөд тайлант онд 5,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Гэвч тухайн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ 2022 онд дууссан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	5,000.0	-	-	1	5,000.0	-	-	-	-	
	Завхан салбар, Тайшир Гуулин УЦС ХХК нь 10,912.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, эрчим хүчний тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг сольж засварласан талаар техникийн комисс ажилласан нь тодорхойгүй, акт үйлдээгүй.	2	10,912.1	-	-	-	-	-	2	10,912.1	-	-
	Үйлчилгээний барилгын халаалтын систем шинэчлэх ажлын санхүүжилт 19,000.0 мянган төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлэхдээ гэрээний заалтыг зөрчиж, ажлыг хүлээлгэн өгөөгүй, нэхэмжлэх үүсгээгүй байхад урьдчилж шилжүүлсэн байна.	1	19,000.0	-	-	-	1	19,000.0	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>34,912.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>24,000.0</b>	<b>2</b>	<b>10,912.1</b>	<b>-</b>	<b>-</b>	

Үүнээс:

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр														
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Өөрчлөлтий	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан											
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	2					3	4	5	7	8	9	10				
A	1																				
	ТӨҮГ			1																	
	НИЙТ			1																	